

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын  
2013 оны 12 дугаар сарын 20 өдрийн  
А-367 тоот тушаалын хавсралт

## БАТЛАВ

ХОВД АЙМГИЙН БАЙГАЛЬ  
ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГА  Л.БАТБАЯР  
841861306  
ПЮА8039 348



ДЭД ЗАХИРАЛ  Ж.ОЮУНЧИМЭГ  
5141583 ХАК111

## УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2020 оны 1 сарын 15 өдөр

Дугаар /2020/1

Ховд хот

### Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7 29.1 заасны дагуу Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргааны гаргасан 2020 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 1 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын олгосон 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн А/01 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Ховд аймаг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ус, усны нөөц хариуцсан мэргэжилтэн Т.Бямбажаргал.

Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 4-р хороо Сөүлийн гудамж, Түшиг төв, 3-р давхар. Улсын бүртгэлийн дугаар 9019023025, регистрийн дугаар 5141583, Утас-976-7711-0567

"МоЭнКО" ХХК"-ний ахлах гидрогеологич Б.Басбаатар нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

### Хоёр. Гэрээний гол нөхцөл:

#### 2.1. Ус ашиглах зориулалт:

Нүүрсний ачилт буулгалт хийх, даацын автомашин байрлах тээвэр ложистикийн талбай байгуулах.

## **2.2. Ашиглах усны хэмжээ:**

- 2.2.1 Унд ахуй- 1095 м<sup>3</sup>
- 2.2.2 Замын тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ - м<sup>3</sup>
- 2.2.3 Ногоон байгууламж усалгаанд- 4704 м<sup>3</sup>
- 2.2.5 Болзошгүй усны хэрэглээ-2190 м<sup>3</sup>

## **2.3. Усны чанар найрлага:**

Усанд ямар нэг хүнд металл илрээгүй, Сг, Рь, Сь, N 2п-н байх ёстой стандарт түвшиндээ байна. Унд ахуйд ашиглах усны дээжийн үзүүлэлт, заалтууд нь уух усны зөвшөөрөгдсөн хэмжээнд байгаа тул усыг хэрэглэж болно гэсэн дүгнэлт гарсан.

## **2.4. Усны эх үүсвэрийн байршил:**

Үенч сумаас 10 км зайд байрлах Цагаан түнгэ багийн нутагт байрлах гүний худгаас усаа ашигладаг.

### **1. Солбилцол:**

Х	Ү
91°58'28.41"	45°58'32,56"
91°58'41.31"	45°58'46,06"
91°59'20.02"	45°58'28,13"
91°59'7.12"	45°58'17,66"

## **2.5. Хаягдал бохир усны хэмжээ:**

Унд ахуйд жилд 6898 м<sup>3</sup> ус хэрэглэж ахуйн бохир усыг бохир усны цооногоор дамжуулан хөрсөнд шууд нэвчүүлж зайлуулна.

## **2.6. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:**

Ховд аймгийн Үенч сумын нутагт "Гаалийн хяналтын талбай" байгуулах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2017 онд "Юу Эм Си Эм" ХХК хийж гүйцэтгэсэн.

## **2.7. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх аргаа хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:**

Ус ашиглах боломжит нөөцийн хүрээнд үр ашигтай, хэмнэлттэй байдлаар ашиглана. Нүүрсийг дахин буулгах, ачих явцад их хэмжээний тоос тортог агаарт дэгдэж, улмаар энэ нь хөрс ургамлын гадна бууж борооны усаар угаагдан Үенч голын усанд орж, түүний чанарт сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай тул ойр орчимд байгаа гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдлоос сэргийлэх, усан орчны тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж, ажиллах шаардлагатай.

## 2.8. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэж эргүүлж ашиглах:

Эргүүлэн ашиглах ус байхгүй.

## 2.9. Усны тоолуур:

Well-1 дугаартай худганд TLT-50H маркийн 2 тоолуур суулгасан, унд ахуйн болон үйлдвэрийн усны 2 тоолууртай.

## 2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

1. Монгол улсын "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай" хуулийн 20.1.1-д заасны дагуу Үенчийн гаалийн хяналтын талбайн унд ахуйн хэрэгцээн ашиглах 1095 м<sup>3</sup> усыг төлбөрөөс чөлөөлөв.

2. Үенчийн гаалийн хяналтын талбайд ашиглах усны нийт хэрэглээ 7989 м<sup>3</sup> ус хэрэглэх бөгөөд дотоод та Ногоон байгууламж услахад зарцуулах усны хэмжээ 4704 м<sup>3</sup> Болзошгүй хэрэглэх ус 2190 м<sup>3</sup> усыг газрын доорх усны төлбөрийн хэмжээг "Усны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Үенч-Бодонч-Булган голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологийн эдийн засгийн суурь үнэлгээ, "Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруудах тухай" Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтаар тооцох итгэлцүүр" Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох хөнгөлөх" тухай, Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн дугаар тогтоолд заасан хувь хэмжээ, Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргааны 2020 оны 01 дүгээр сарын 08-ны 1 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэж тооцвол:

**2506**-Үенч-Бодонч-Булган голын сав газрын экологи эдийн засгийн суурь үнэлгээ,

**15%**-Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 10-д заасан хувь хэмжээ,

**0,7**-Бусад ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг байгууллага иргэний ашигласан усны ашиглалтын зориулалтын итгэлцүүр,

Болзошгүй ашиглах усны төлбөр  
 $2970 \text{ м}^3/\text{жил} \times 263,13 \text{ төг}/\text{м}^3 = 576254,7$   
**Ногоон байгууламж услахад зарцуулах усны төлбөр**  
 $4704 \text{ м}^3/\text{жил} \times 175 \text{ төг}/\text{м}^3 = 823,200$   
**Нийт усны төлбөр:  $823,200 + 576,254 = 1,399,454$**

**/Нэг сая гурван зуун ерөн есэн мянга дөрвөн зуун тавин дөрвөн/ төгрөг**

Усны төлбөрийг баталгаажсан тоолуурын заалтыг үндэслэн сард 1 удаа Ховд аймгийн Төрийн сан банкны 160000944 тоот дансанд шилжүүлнэ.

## 2.11 Ус ашиглуулагчаас тавигдах шаардлага

1. Ус ашиглагч нь 2020 оны 12 дугаар сарын 20-ны дотор ус ашиглалтын тайланг Байгаль очрин, аялал жуулчлалын газарт хүргүүлж биелэлтийг тооцуулна.

2. Усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүс эрүүл ахуйн бүсийг тогтоож, тэмдэгжүүлэлтийн ажлыг хийх шаардлагатай.

3. Ус ашиглах зөвшөөрөл, гэрээ байгуулахаас өмнө холбогдох албан тушаалтныг байлцуулж худгийн тоолуурын заалтыг баталгаажуулж байх.

4. Худгийг камержуулах ажлыг зохион байгуулах.

5. Усны эх үүсвэрийг хамгаалах усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ авч ажиллах.

6. Үенч гол болон худагнаас дээж авч шинжилгээг улирал бүр хийлгэж байх.

7. Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан гадаргын болон газрын доорхи усны

нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах талаар хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөөг мөрдөж ажиллах.

### **Гурав. Талуудын эрх үүрэг**

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1,-д заасны дагуу эрх эдэлж үүрэг хүлээнэ.

### **Дөрөв. Бусад**

- 4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.
- 4.4. Байгаль орчин аялал жуулчлалын газраас ус ашиглагчид хяналт тавин ажиллана. Усны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар шатлан өсгөх хэлбэрээр өсгөж тооцно.
- 4.5. Талуудын тохиролцооноор гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.6. Гэрээг дор дурьдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.
  - 4.6.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.
  - 4.6.2. Аль нэг тал татан буугдсан.
- 4.7. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
ТӨЛӨӨЛЖ:  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
УСНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН

УС АШИГЛАГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:  
“МОЭНКО” ХХК”-НИЙ

МЭРГЭЖИЛТЭН

Т.БЯМБАЖАРГАЛ

**Хаяг:**

Ховд аймаг Жаргалант сум  
Наран баг



АХЛАХ ГИДРОГЕОЛОГИЧ

Б.БАСБААТАР

**Хаяг:**

Улаанбаатар хот Сүхбаатар  
дүүрэг, 4-р хороо, Сөүлийн гудамж,  
Түшиг төв 3-р давхар



**Харилцах утас:** 99935585

**Харилцах утас:** 99065254